



МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

_____ оны _____ сарын _____ өдөр


Дугаар _____

Улаанбаатар хот

Дулааны техникийн нөхцөл олголтыг түр хугацаагаар хязгаарлах тухай

2015-2016 оны халаалтын улирал эхэлж өвлийн их ачааллын горимд шилжиж байгаатай уялдуулан Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцын дулаанжуулалтын тоноглолын хүчин чадал, дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадварын судалгаа, шинээр холбогдсон болон холбогдох хэрэглэгчийн тооцоо судалгааг хийх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбох техникийн нөхцөл олголтыг 2015 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.
2. Техникийн нөхцөл олголтыг түр хугацаагаар хязгаарлаж байгаатай холбогдуулан сүлжээний гидравлик тооцоог хийж эх үүсвэр шугам сүлжээний нөөцийн судалгааг нарийвчлан гаргахыг ЭХЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга бөгөөд ЭХЯ-ны “Техникийн нөхцөл олгох комисс”-ын дарга П.Товуудорж, “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер бөгөөд техникийн нөхцөлийн комиссын дарга Т.Алтангэрэл нарт даалгасугай.

САЙД  Д.ЗОРИГТ